

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ
ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН
МЭДҮҮЛСЭН ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ТӨРИЙН
БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2024 оны 04 дүгээр
сарын 11-ний өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд, Л.Мөнхбаатар, Г.Тэмүүлэн нараас 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. ...” гэж заасан бөгөөд Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд уг өөрчлөлтөд бусад хууль тогтоомжийг нийцүүлэхээр “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 44 дүгээр тогтоолыг баталж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар тогтсон болно.

Хууль санаачлагч Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг нэг зуун хорин зургаан гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үр дүнтэй зохион байгуулах, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй байлгах, асуудлыг ажил хэрэгч, шударга мэтгэлцээний зарчмаар шийдвэрлэх, түүнчлэн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх, оролцоо, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхдээ дэлхийн зарим орны парламентын дэгийн сайн туршлагаас холбогдох зохицуулалтыг нэвтрүүлэх, Монголын парламентын үйл ажиллагаанд нутагшуулах зэрэг асуудалд анхаарч хуулийн төслийг боловсруулсан байна.

Хуулийн төсөл батлагдсанаар гишүүдийн асуулт асуух, үг хэлэх, санал хураах журам, дэг тогтоох олон улсын жишигт нийцсэн мэтгэлцээний зарчим тусгагдсан, хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгож, төслийг чанартай, хийдэлгүй батлагдах нөхцөл хангагдсан, чуулганы хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлага нэмэгдэх, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг ойлгомжтой, нэг мөр хэрэглэгдэх боломж бүрдэнэ гэж үзжээ.

Дээрх хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын “d.parliament.mn” цахим системд байршуулсан болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Байнгын хорооны даргыг сонгох журам, Улсын Их Хурлын өмнөх бүрэн эрхийн хугацаанд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг буцаахгүй үргэлжлүүлэн хэлэлцэх боломжийн талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Туваан чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллыг хэрхэн тогтоох, хуулийн төслийг

өргөн мэдүүлэх, тов тогтоох асуудлыг нарийвчлан зохицуулсан эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.


Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63.6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Н.ЭНХБОЛД